

## **Олон Улсын Театрын өдөр 2018 – Америк тив**

**Сабина Берман, Мексик улс**

Зохиолч, жүжгийн зохиолч, сэтгүүлч

Бид төсөөлж чадна.

Овгийнхон жижиг чулуу аван агаарт нисч буй шувууд руу шидэн агнана, тэр агшинд аварга том арслан заан тайзнаа архиран үсрэн гарч ирнэ – бүгд яг нэг мөчид болно, арслан заан адил харин жижигхэн биетэй бүсгүй архирах аж. Тэгтэл бүх хүн зугтан гүйлдлээ....

Эмэгтэйн дуугарсан тэрхүү арслан зааны архиралт – чухамдаа бүсгүй хүн ингэсэн гэж би төсөөлөх дуртай – эн бол бидний төрлийн бий болгосон тэр л эх үндэс маань юм. Бид өөрөө биш бусад бүх зүйлийг дуурайх чадвартай тийм л төрөл. Өөр бусдыг төлөөлөх чадвартай тийм л төрөл.

Урагш арван жил, эсвэл зуу үгүй бол мянган жил алгасаад үзье. Овгийнхон бусдыг дуурайж сурчээ; агуйн гүнд, сүүмэлзэн асах түүдэг галын дэргэд, дөрвөн эр арслан заан, гурван бүсгүй гол, бусад эрчүүд хүүхнүүд шувууд, модод, үүлс гээд л. Овгийнхон өглөөний авыг үзүүлжээ, ингэж л тэд жүжиглэх авьяас билгийнхээ ачаар өнгөрснийг дүрслэн үзүүлдэг. Бүр гайхамшигтай нь овгийнхон байж болох ирээдүйгээ, овгийнхны дайсан болсон арслан зааныг үгүй хийх олон боломжит арга замуудыг нээн олжээ.

Архирах, исгэрэх, дүнгэнэлдэх – энэ бүгд анхны театрын эхлэл – энэ нь үг бүхий хэл болно. Бидний ярьж хэлцдэг хэл бичгийн хэл болно. Харин эсрэгээрээ театр зан үйл, тэгээд дараа нь кино болж хувирна.

Гэвч орчин үеийн энэ олон хэлбэрүүдэд, тэднийг бий болгосон уг үндэст хүртэл театр оршин байсаар байна. Төлөөллийн хамгийн энгийн хэлбэр. Цорын ганц илэрхийлэх хэлбэрийн амьд хэлбэр.

Театр: энгийн байх тусмаа бидний хүний хамгийн гайхамшигтай чадвар болох бусдыг төлөөлөх тэр чадвартай биднийг туйлын ойр дотно холбож өгч байдаг юм.

Өнөөдөр, дэлхийн бүх театруудад бид хүн төрөлхтний энэхүү гайхамшигтай чадварыг тэмдэглэн баярлаж байна. Ингэснээрээр бидний өнгөрснийг ойртуулан авчирч – хүн төрөлхтөн хэмээх овгийнхонд эрх чөлөө, аз жаргал авчрах боломжит ирээдүйг нээн илэрхийлж чадна.

Хүн төрөлхтний устгавал зохих арслан заанууд юу вэ? Орчин цагийн дайсан чухамдаа юу юм бэ? Театр юуг зугаа цэнгэлээс дээгүүр тавьж зорин тэмүүлэх ёстой юм бэ?

Миний хувьд, бидний хамгийн том арслан заан бол хүн төрөлхтөн сэтгэл зүрхгүй болж буй явдал. Бусдыг мэдрэх чадвараа гээх: өөрөөсөө өөр хүн болоод амьд юмсыг энэрэх сэтгэлгүй болох.

Юутай харамсалтай! Өнөөдөр, хүн төрөлхтөн эцсийн зогсоолдоо ирлээ – шинэ эриний хүн – хүн төрөлхтөн өөрийн эргэн тойронд байгаа бүгдийг өөрчлөх хүч болсон бөгөөд цаашид ч өөрчилсөөр байх болно. Харин театрын зорилго бол үүний яг эсрэг байх ёстой. Агуйн гүнд театр үүсч нэгэн овгийн цуглуулдаг байсан тэр цэг үеийн адил өнөөдөр бид байгаль дэлхийтэйгээ холбогдсон тэр хүн холбоогоо театраар дамжуулж аврах ёстой юм.

Уран зохиолоос ч тэр, киноноос ч тэр бүр илүүтэйгээр театр хүнийг хүнд таниулж өмнө нь илэрхийлж байдаг – биднийг алгоритмууд, цэвэр хийсвэрлэлээс аврахад хамгийн гайхалтай тохирох нь театр.

Театраас илүүдэл бүх зүйлийг гарган зайлуулъя. Юу ч үгүй болтол нь хоосолъё. Учир нь театр энгийн байх тусмаа бидэнд үгүйсгэж хэзээ ч үл чадах нэг зүйлийг сануулахад нэн тохиромжтой. Энэ бол бид энэ цаг үед, бидний цээжинд зүрх маань цохилон бие махбод байгаа л бол бид энд, яг одоо байна гэсэн үг. Маргааш гэж үгүй.

Театр өнө мөнх оршиг! Хамгийн эртний урлаг, бусдын төлөөлөх энэ л урлаг бол хамгийн гайхамшигтай урлаг мөн. Театр өнөх мөнх оршин байг!

Орчуулсан Н. Болороо